

МОНГОЛ УЛСЫН АНХНЫ КАРТОГРАФИЧ ГАЗАРЗҮЙН УХААНЫ ДОКТОР ДАШНЯМЫН БАДАМЖАВ

Газрын зураг зохиож улс орны нийгэм, эдийн засгийн хүрээнд ашиглах ажил эртний түүхтэй юм. Монголын уламжлалт аргаар зохиосон анхны зургууд XII-XIII зуунд хамаарагддаг бөгөөд энэ төрлийн зураг бүр XX зууны эхэн үед хүртэл зохиогдож байжээ [1].

1722 оноос эхлэн Монголын аймаг, хошууд, шавь, хилийн харуул, өртөө замын газар нутгийн зургийг муутуу цаас болон даавуун дээр монгол зургийн уламжлалт аргаар зохиож байжээ[1].

Гар аргын ийм зургууд шинэ үеийн боловсрол, эдийн засгийн хэрэгцээг хангаж чадахгүй болсон учир зурагзүйн шинжлэх ухааны шаардлагад тохирсон газрын зураг бүтээх ажил 1921 оны ардын хувьсгалын дараагаар өрнөсөн бөгөөд анхан шатны сургуулиудад үзэх дэлхийн тивүүд болон Монгол орны зургийг Герман улсад захиалан хийлгэсэн байдаг[2].

Газрын зургийг дотооддоо зохиож хэвлэхийг Шинжлэх ухааны хүрээлэнд А.Д.Симуков анх сэдэж 1934 онд Монголын газарзүйн атлас, 1937 онд 1:2 000 000 масштабтай газрын зураг зохиож улсын хэвлэх үйлдвэрт хэвлүүлсэн нь тэр үеийн сүрхий ололт болсон юм[2].

Энэ үеэс хойш тус улсын нутаг топографийн зураглалаар бүрэн хамрагдсан нь сургалтын болон бусад хэрэгцээний зургийг онол аргазүйн өндөр хэмжээнд зохиох бололцоо олгосон байна.

Үүнийг хэрэгжүүлсэн анхны зургийн нэг нь 1959 онд Д.Бадамжавын зохиосон 1:1 500 000 масштабтай газарзүйн зураг юм. Зурагзүйн мэргэжилтэй үндсэний эрдэмтэд төрж гарснаар зурагзүйн онолын судалгаа явагдах болжээ[2].



**Газарзүйн ухааны доктор Дашнямын
Бадамжав (1920-1994)**

Д.Бадамжав 1920 онд ОХУ-ын Буриад улсын Шивэрт гэдэг газар төрсөн. 1940-1946 онд Москвагийн их сургуулийн Газарзүйн факультетийг зурагзүйч мэргэжлээр суралцаж төгссөн Монгол улсын анхны картографич юм.

Д.Бадамжавын ажил хөдөлмөр эрхэлсэн байдал:

-1935-1940 онд Шинжлэх ухааны хүрээлэнд дагалдан ба техник ажилтан,

-1946-1981 онд Шинжлэх ухааны хүрээлэнд Газарзүйн кабинетийн эрхлэгч,

-1951-1954 онд мөн хүрээлэнд Эрдэмтэн нарийн бичгийн дарга,

-1954-1958 онд Орос улсын ШУА-ийн Газарзүйн хүрээлэнд аспирантурт суралцсан

-1959-1961 онд Шинжлэх ухаан, Дээд

боловсролын хүрээлэнд эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Газарзүйн тасгийн рэхлэгч, Эрдэмтэн нарийн бичгийн дарга,

-1961-1962 оны 7-р сар хүртэл Шинжлэх ухаан, Дээд боловсролын хүрээлэнд Газарзүй-Геологийн хэлтсийн эрхлэгч,

-1962-1977 онд Газарзүй, Цэвдэг судлалын хүрээлэнд Эрдэмтэн нарийн бичгийн дарга,

-1978-1981 он хүртэл мөн хүрээлэнгийн Картографийн секторын эрхлэгч, эрдэм шинжилгээний ахлах ажилтнаар ажиллаж байсан.




Монгол улсаас Москвагийн Их сургуулийн аспирантурт суралцагсад

Д.Бадамжав 1958 онд ЗХУ-ын ШУА-ийн Газарзүйн хүрээлэнд “БНМАУ-ын Дорнод хэсгийн эдийн засгийн газарзүйн тодорхойлолт” сэдвээр газарзүйн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалж, 1960 онд доцент цол хүртсэн байна [3].

1950-аад оны эцсээр Газарзүйн кабинетаас зурагзүйн чиглэлээр хийгдсэн нэг томоохон ажил бол МАХН-ын Төв хороо, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1959 оны 6-р сарын 25-ны өдрийн 248/219 дугаар тогтоолоор “Тус улсын бүх сумын хилийг тогтоож, нийт нутаг дэвсгэр дээр аж ахуй хоорондын газар зохион байгуулалт явуулах тухай” тогтоолоор хийгдсэн сум нэгдэл, сангийн аж ахуйд эдэлбэр газар хуваарилан олгох юм. Энэ ажилд уг тогтоолоор (7-р зүйл) комиссын гишүүдэд Д.Бадамжав (ШУДБХ) томилогдон ажиллажээ [6].

1937 оноос хойш тус улсын нутаг топографийн зураглалаар бүрэн хамрагдсан нь сургалтын болон бусад хэрэгцээний зургийг онол аргазүйн өндөр хэмжээнд зохиох бололцоо олгожээ. Үүнийг хэрэгжүүлсэн анхны зургийн нэг нь 1959 онд Д.Бадамжавын зохиосон 1:1 500 000-ын масштабтай газар дүрсийн ханын зураг юм. Уг газар дүрсийн ханын зургийг Шинжлэх ухааны хүрээлэнгээс эрхлэн тэр үед зурагзүйн шинжлэх ухааны хөгжил, газрын зураг хэвлэх хэвлэлийн чанарын түвшин өндөр байсан БНАГУ-д хэвлүүлжээ. Энэ зураг нь олон сэдэвт үзүүлэлтүүдийг нэг дор харуулснаараа танин

мэдэхүйн мэдээллийг бүрэн хангаж чадсан ерөнхий газарзүйн зураг болно. Уг газрын зураг нь байгаль, нийгмийн үзэгдлийг тусган харуулсан манай анхны ерөнхий газарзүйн зургийг зурагзүйн орчин үеийн аргад тулгуурлан зохиохдоо газрын зургийн элементүүдийг анх удаа маш толорхой, бүрэн тусган үзүүлсэн байдаг [4].



Энэхүү “Бүгд Найрамдах Монгол Ард Улс” газар дүрсийн зураг нь хэрэглэгч олны дунд “улаан зураг” нэрээр алдаршсан байна. Энэ нь түүний хотгор гүдгэрийн ангиллын өндрийн хуваарийг шараас улаан өнгө хүртэл 9 шатлалаар авч үзүүлэхдээ 1000 м-ээс дээш шатлалд улааныг голлосон тул улаан өнгөтэй харагддаг билээ. Өндрийн хуваарийг 1200 м хүртэл 200 м, 1200-2000 м хүртэл 400 м, түүнээс дээш 600 м, 800 м гэж ангилан шатлалыг авсан нь тал, говь хосолсон уудам нутагтай монгол орны хувьд горизонталын ялгаа нь тохиромжтой бөгөөд харагдац сайтай байхаар сонгосон тул олон нийтийн талархал хүлээсэн бүтээл болсон юм.

Монголын газарзүйн шинжлэх ухаанд оруулсан картографийн монгол зохиогчтой анхны энэ бүтээл нь дунд, дээд сургуульд сургалтын материал болж байсан чухал ач холбогдолтой бөгөөд олон үеийнхэн мэдлэг олж авсан төдийгүй улс ардын аж ахуйн төлөвлөлтөд ч ашиглагдсанаас гадна үүний дараа зохиогдсон олон зургийн суурь болж өгсөн юм.

1956 онд МУИС-д Газарзүйн ангийг нээж, үндэсний боловсон хүчнийг бэлтгэх болсон. Газарзүйн тэнхимд ШУХ-ийн Газарзүйн кабинетын Д.Бадамжав болон бусад эрдэмтэд хичээл зааж байв.

Газарзүйн хүрээлэн байгуулагдсанаас хойших хугацаанд газарзүйн судалгааны арвин материал хуримтлагдсаны дотор газарзүйн нэр ороогүй бүтээл үгүй бөгөөд түүнээс

гадна газар усны нэрийг тодотгох ажлыг Д.Бадамжав болон түүний нөхөд Д.Базаргүр, Ж.Буджав нар 1960-аад оноос 1:200 000 масштабаар улсын хэмжээнд цуглуулсан байна [5].

Үүний дараагаар 1965, 1966 онуудад сургалтанд зориулсан БНМАУ-ын газарзүйн атлас, Ерөнхий газарзүйн Атлас, БНМАУ-ын засаг захиргааны хуваарь зэрэг хэд хэдэн ханын зураг хэвлүүлсэн байна.

Д.Бадамжав 1962-1964 онуудад БНМАУ, БНХАУ-ын хооронд, 1975-1979 онд БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд, 1981-1984 онд БНМАУ, БНХАУ-ын хооронд улсын хилийн шугамыг хамтран шалгах, газар дээр тогтоон тэмдэглэх улсын комиссын Монголын талын нарийн бичгийн даргаар (эрдэмтдийн төлөөлөл) болон тус бүрэлдэхүүнд 5 удаа оролцож, улс орны тусгаар тогтнолын баталгаа болсон улсын хилийг тэмдэгжүүлэх, зурагжуулах ажлыг нэр төртэй гүйцэтгэсэн гавьяатан билээ.



БНМАУ, БНХАУ-ын хооронд улсын хилийн шугамыг хамтран шалгах, газар дээр тогтоон тэмдэглэх улсын комиссын гишүүдийн хамт. Бээжин хот

Энэ ажлын тухай Монгол Улсын гавьяат барилгачин, хөдөлмөрийн баатар Б.Рагчаа “БНМАУ-БНХАУ-ын хооронд 1962 онд, БНМАУ-ЗСБНХУ-ын хооронд 1976 онд тус тус байгуулсан хилийн гэрээний дагуу газар дээр нь тогтоон тэмдэглэхдээ геодези газрын зургийн 2 талын мэргэжилтнүүд хилийн багана босгох цэг нэг бүрийн байршлыг газар дээр нь тодорхойлж өгч босгуулах, хилийн зурвасыг 1:100000, 1:50000, 1:10000-ын байрзүйн зураг үйлдэж оруулах... гэх мэт ажлыг хариуцдаг гэж (2010) тэмдэглэсэн байна. Энэ ажлын үр дүнд 1964 онд БНМАУ-БНХАУ-ын хооронд 2 улсын хилийн тухай гэрээ (4хх), хилийн

шугамын тодорхойлолт-протокол (22хх), хилийн тухай протокол (29хх), хилийн зурвасын газрын зургийн альбом, (112 зурагтай), БНМАУ-ЗСБНХУ-ын хилийн протокол 155 хуудас, (1979), мөн протокол 137 хуудас (1984) он газрын зураг 160 гаруйг (маш нууц) тус тус зохиосон байна. (Д.Бадамжавын хувийн архиваас) 1964 онд БНМАУ-д айлчлан 2 улсын хилийг тогтоосон хэлэлцээрт гарын үсэг зурахад дэд эрдэмтэн Д.Бадамжав Монголын эрдэмтдийг төлөөлөн оролцжээ [6].



БНМАУ-ЗСБНХУ-ын хоорондын хилийн хэлэлцээрт тус 2 орны төлөөлөгчид гарын үсэг зурж буй нь. Арын эгнээнд Д.Бадамжав



БНМАУ-БНХАУ-ын хоорондын хилийн хэлэлцээрт тус 2 орны төлөөлөгчид гарын үсэг зурж буй нь. Бээжин хот. 1964 он. Арын эгнээнд Д.Бадамжав

1971 оноос зурагзүйн тасгийн хамт олон “БНМАУ-ын иж бүрэн атлас зохиох” ажлыг эхэлжээ. Энэ нь “БНМАУ-ын Үндэсний Атлас”-ыг зохиох ажлын эхлэл байлаа. Үндэсний Атласын эрдэм шинжилгээний зөвлөхөөр дэд эрдэмтэн Д.Бадамжав ажиллаж, энэхүү бүтээл нь 20-р зууны Монголын шинжлэх ухааны шилдэг бүтээл болсон билээ [6].



Үндэсний Атлас зохиох ажлын хэсгийн хуралдаан

Энэ бүхнээс үзвэл доктор Д.Бадамжав бол Монгол оронд газарзүйн болон зурагзүйн шинжлэх ухааныг үүсгэн хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, Газарзүйн хүрээлэнг үндэслэгчийн нэг, зурагзүйн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, улсын хилийг тэмдэгжүүлэх, зурагжуулах ажилд ихээхэн хүчин чармайлт гаргаж, идэвхтэй үүрэг гүйцэтгэсэн эрдэмтэн хүн юм.



Д.Бадамжав нь Монгол улсад орчин цагийн Газарзүйн шинжлэх ухааныг үндэслэгч, тэр дундаа Зурагзүйн ухааныг үүсгэн хөгжүүлэх, боловсронгуй болгох, бэхжүүлэхэд анхнаас нь оролцож, эрдэм мэдлэг, оюун санаагаа зориулсан шинжлэх ухааны томоохон зүтгэлтэн байв. Түүний шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр, хөдөлмөр бүтээлийг үнэлж Монгол улсын төр засгаас "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон", "Алтан гадас" одон, Хөдөлмөрийн хүндэт медалиар 2 удаа, Ардын хувьсгалын 25 жил, 40 жилийн ойн медалиудаар шагнасны зэрэгцээ ЗХУ-ын засгийн газар "Хүндэтгэлийн одон"-гоор шагнажээ. Мөн хоёр хөрш оронтойгоо хилийн асуудлыг шийдвэрлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлэн “онц хилчин” цол тэмдгээр шагнагдсан нь шинжлэх ухааны анхны эрдэм шинжилгээний ажилтан болсон билээ.

Ашигласан материал

- [1] Д.Даш (Ред.) “Эрдэмтэд, судлаачдын тухай өгүүлэх нь” УБ., 2021. 61.
- [2] Ш.Цэгмид. Газарзүйн шинжлэх ухаан монголд, Улаанбаатар хот 2003 он.
- [3] Д.Даш, Н.Мандах. Газарзүйн шинжлэх ухааны хөгжлийн түүх, Ред. Ж.Нацаг, П.Цолмон, Улаанбаатар хот 2011 он.
- [4] Д.Энхбаяр. Газарзүйн хүрээлэнг үндэслэгч, эрдэмтэн Д.Бадамжав // МОГЗА, №7, х.219-224.
- [5] Газарзүйн хүрээлэн 40 жил. Улаанбаатар хот 2002 он.
- [6] Газарзүйн хүрээлэн 50 жил. Улаанбаатар хот 2012 он.